



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/755

Булган сум

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга  
Нарийн бичгийн дарга: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын газар,  
газрын хэвлийн ашиглалт, хамгаалалт хариуцсан  
мэргэжилтэн  
Гишүүд: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль  
орчны хяналтын Улсын байцаагч  
Сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан  
мэргэжилтэн  
Сумын байгаль орчны хяналтын Улсын байцаагч  
Сумын байгаль хамгаалагч  
Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл

2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж холбогдох мэдээллийг аймгийн Засаг даргад танилцуулахыг ажлын хэсгийн дарга (А.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/577 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

Сугар Ажил 2023 өдөр Doc/2023/Захирамж

6323010876